



**Харилцаа холбооны зохицуулах хорооны
2023 оны ээлжит 07 дугаар хуралдааны
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны ээлжит 07 дугаар хуралдааныг 2023 оны 06 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулав.

Зохицуулах хорооны 2023 оны ээлжит 07 дугаар хуралдаанаар Шуудангийн илгээмж хүргэх хугацааг тогтоох тухай; Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах, нэмэлт өөрчлөлт оруулах тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох, Дугаар ашиглалтын хугацааг сунгах тухай үнэлгээ, дүгнэлтийн тухай; Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай; Статистик тайлан мэдээг хугацаандаа ирүүлээгүй ААН-ийн ТЗ-ийг түдгэлзүүлэх тухай); Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл 2023 онд олгох нээлттэй сонгон шалгаруулалтын үнэлгээний тайлан, дүгнэлтийн тухай (Хорооны 2023 оны 35 тоот тогтоолыг хэрэгжүүлэх); 5G Дараа үеийн хөдөлгөөнт холбооны үндсэн ойлголт судалгааны тайлангийн танилцуулга болон 5G Дараа үеийн хөдөлгөөнт холбооны үйлчилгээг Монгол Улсад нэвтрүүлэх хэрэгцээ судалгааны танилцуулга; ХХЗХ-ны шийдвэртэй холбоотой, одоо үргэлжилж буй шүүхийн маргааны талаарх мэдээлэл зэрэг 10 гаруй асуудлыг тус тус хэлэлцэн зохицуулах хорооны 15 тогтоолыг батлан шийдвэрлэв.

Шуудангийн тухай хуульд 2019 оны 05 дугаар сарын 30-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулснаар хуулийн 9.1.6-д заасны дагуу Харилцаа холбооны зохицуулах хороо нь шуудангийн илгээмж хүргэх хугацааг тогтоож, мөрдүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэхээр болсон. Түүнчлэн Зөвшөөрлийн тухай хууль 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээр энэхүү хуулийн шинэчилсэн найруулгад салбарын зохицуулалтын журам, баримт бичгүүдийг нийцүүлэх, давхардал, хийдлийг арилгах, шинээр батлах, нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлж байгаа билээ. “Дотоодын болон улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ыг ХХЗХ-ны 2023 оны 23 тоот тогтоолоор шинэчлэн батлуулж, ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 6194 дүгээрт бүртгүүлсэн болно. Цаашид хуулийн дагуу дотоодын болон улс хоорондын шуудангийн илгээмж хүргэх хугацааг тогтоох шаардлага үүссэн болно. Иймээс Шуудангийн зохицуулалтын газар, Хуулийн хэлтсээс хамтран Зохицуулах хорооны 2023 оны ээлжит 07 дугаар хуралдаанд шуудангийн илгээмж хүргэх хугацааг тогтоохоор боловсруулсан танилцуулга, тогтоолын төсөл, нөлөөллийн шинжилгээний төсөл, саналын товчоог боловсруулан хэлэлцүүлэв. Тус хуралдаанаас Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.6 дахь заалтыг үндэслэн 2023 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 57 тоот “Шуудангийн илгээмж хүргэх хугацааг тогтоох тухай” тогтоолыг батлав. Уг тогтоолд, Улс хоорондын болон дотоодын шуудангийн илгээмж хүргэх хугацааг дараах байдлаар тогтоосугай. Үүнд: Ердийн зэрэглэлийн илгээмжийг хотын дотор 2 хоног, аймаг, хотын хооронд 5 хоног, бусад газар (улс хооронд)-т 12 хоногийн дотор; Буухиа зэрэглэлийн илгээмжийг хүргэх хугацааг үйлчлэгч хоорондын гэрээнд зааснаар тодорхойлох бөгөөд энэхүү

тогтоолын 1.1 дэх хэсэгт заасан хугацаанаас бага байхаар тогтоож баталжээ. ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлд хянуулан нэмэлтээр бүртгүүлэхээр ХХЗХ-ны Даргын 2023 оны 01/851 албан тоотоор хүргүүлсэн ба ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн 6270 тоот улсын бүртгэлд 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдөр шинээр бүртгүүлэн мөрдөж эхлээд байна.

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 6 дугаар зүйл, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, мөн зүйлийн 7.4.1, 7.4.2, 7.4.5 дахь заалтууд, 30 дугаар зүйлийн 30.1.9 дэх заалтыг тус тус үндэслэн 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 35 тоот “Тусгай зөвшөөрлийн тоо батлах тухай” тогтоолыг хавсралтын хамт баталсан. Тогтоолд, Харилцаа холбооны зохицуулах хорооноос 2023 онд нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох “Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо, нээлттэй сонгон шалгаруулалт зарлах хугацаа”-г тогтоож шийдвэрлэсэн. Уг тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд 2023 оны 35 тоот тогтоол, хавсралтад заасан сонгон шалгаруулалтыг Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль болон холбогдох бусад дүрэм, журамд заасан хугацааг баримтлан Зохицуулах хорооны ажлын албанаас зохион байгуулсан болно. ХХЗХ-ны 2023 оны ээлжит 07 дугаар хуралдаанд тус хорооноос Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 8.1 дүгээр зүйлийн 9.6 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 7.4.5 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны 35 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “2023 онд нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо” (Хорооны 2023 оны 35 тоот тогтоолыг хэрэгжүүлэх) зорилгоор зарласан Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл 2023 онд олгох нээлттэй сонгон шалгаруулалтын үнэлгээний тайлан, дүгнэлтийн тухай авч хэлэлцээд, тус хорооны 2023 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 67, 68, 69, 70, 71 тоот “Нээлттэй сонгон шалгаруулалтад шалгарсанд тооцож, тусгай зөвшөөрөл олгох тухай” тогтоолыг хавсралтын хамт тус тус батлахаар шийдвэрлэв.

Зохицуулах хорооны 2023 оны ээлжит 07 дугаар хуралдаанд тус хорооны Хуулийн хэлтсээс боловсруулсан ХХЗХ-ны тогтоол шийдвэртэй холбоотой, одоо үргэлжилж буй шүүхийн маргааны талаарх мэдээллийг сонсов.

ХХЗХ-ны 2023 оны ээлжит 07 дугаар хуралдаанаар Тусгай зөвшөөрлийн тухай (-ТЗ шинээр олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах, нэмэлт өөрчлөлт оруулах тухай үнэлгээ, дүгнэлт; -Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох, -Дугаар ашиглалтын хугацааг сунгах тухай үнэлгээ, дүгнэлтийн тухай; -Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай; -Статистик тайлан мэдээг хугацаандаа ирүүлээгүй ААН-ийн ТЗ-ийг түдгэлзүүлэх тухай); Нээлттэй сонгон шалгаруулалтад шалгарсанд тооцож, тусгай зөвшөөрөл олгох тухай холбогдох ажлын хэсэг, газар хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээний дүгнэлт бүхий 14 тогтоол, хавсралтын төслийг тус тус авч хэлэлцээд, тус хуралдаанаас 14 тогтоолыг хавсралтын хамт баталсан. Үүнд:

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх

- хэсгийг тус тус үндэслэн 2023 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 58 тоот тогтоолын хавсралтаар 5 хуулийн этгээдэд 5 тусгай зөвшөөрлийг шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5¹.1.8 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн 2023 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 59 тоот тогтоолын хавсралтаар 8 хуулийн этгээдийн 10 тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан;
 - Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн 2023 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 60 тоот тогтоолын хавсралтаар 2 хуулийн этгээдийн 2 тусгай зөвшөөрлийн радио давтамжийн зурвас, радио төхөөрөмж, хамрах хүрээнд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан;
 - Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалт, Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журмын 4.4 дэх хэсгийг тус тус үндэслэн 2023 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 61 тоот тогтоолоор 2 хуулийн этгээдэд 2 харилцаа холбооны сүлжээний дугаарыг нэмж олгосон;
 - Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалт, Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журмын 4.4 дэх хэсгийг тус тус үндэслэн 2023 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 62 тоот тогтоолын хавсралтаар 5 хуулийн этгээдийн харилцаа холбооны сүлжээний 5 дугаар ашиглалтын хугацааг сунгасан;
 - Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт болон Райт ап консалтинг ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2023 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 63 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон;
 - Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.2 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалт, Радио долгионы тухай 5¹ дүгээр зүйлийн 5¹.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн 2023 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 64 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон;
 - Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.2 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн 2023 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 65 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон;
 - Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.1 дүгээр зүйлийн 1.2 дахь заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.12.2 дахь заалт, 14.12.3 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалт, тус тус заасны үндэслэн 2023 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 66 тоот тогтоолын хавсралтаар 29 хуулийн этгээдийн 29 тусгай зөвшөөрлийг 45 хоногийн хугацаагаар түдгэлзүүлсэн;

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 8.1 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 7.4.5 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны 35 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “2023 онд нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо”, тус хорооноос зарласан “APP-Орон нутаг 2023: Орон нутагт арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалт”-ын үнэлгээний ажлын хэсгийн 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн дүгнэлтийг тус тус үндэслэн 2023 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 67 тоот тогтоолын хавсралтаар тус хорооноос зарласан Орон нутагт арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох “APP-Орон нутаг 2023” тоот нээлттэй сонгон шалгаруулалтад Дадишуар гоёл ХХК-ийг шалгарсанд тооцож, “Арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх” болон “Радио давтамж ашиглах” тусгай зөвшөөрлийг олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 8.1 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 7.4.5 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны 35 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “2023 онд нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо”, тус хорооноос зарласан “APP-Орон нутаг 2023: Орон нутагт арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалт”-ын үнэлгээний ажлын хэсгийн 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн дүгнэлтийг тус тус үндэслэн 2023 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 68 тоот тогтоолын хавсралтаар тус хорооноос зарласан Орон нутагт арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох “APP-Орон нутаг 2023” тоот нээлттэй сонгон шалгаруулалтад Одтой цэг ХХК-ийг шалгарсанд тооцож, “Арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх” болон “Радио давтамж ашиглах” тусгай зөвшөөрлийг олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 8.1 дүгээр зүйлийн 9.6 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 7.4.5 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны 35 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “2023 онд нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо”, тус хорооноос зарласан “ОСДҮ-Дорноговь аймагт 2023: Дорноговь аймгийн нутаг дэвсгэрт олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалт”-ын үнэлгээний ажлын хэсгийн 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн дүгнэлтийг тус тус үндэслэн 2023 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 69 тоот тогтоолын хавсралтаар тус хорооноос зарласан Дорноговь аймгийн нутаг дэвсгэрт олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх “ОСДҮ-Дорноговь аймагт 2023” тоот нээлттэй сонгон шалгаруулалтад Мэргэшир-Од ХХК-ийг шалгарсанд тооцож, “Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх” болон “Радио давтамж ашиглах” тусгай зөвшөөрлийг олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 8.1 дүгээр зүйлийн 9.7 дахь хэсэг,

Харилцаа холбооны тухай 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 7.4.5 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны 35 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “2023 онд нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо”, тус хорооноос зарласан “ТВ-Орон нутаг 2023: Орон нутагт телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалт”-ын үнэлгээний ажлын хэсгийн 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн дүгнэлтийг тус тус үндэслэн 2023 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 70 тоот тогтоолын хавсралтаар тус хорооноос 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдөр зарласан Орон нутаг телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох “ТВ орон нутаг 2023” тоот нээлттэй сонгон шалгаруулалтад Дадишуар гоёл ХХК-ийг шалгарсанд тооцож, Дорноговь аймгийн нутаг дэвсгэрт (үйлчилгээ эрхлэх хүрээ), Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт заасан хугацаагаар өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон;

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 8.1 дүгээр зүйлийн 9.7 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 7.4.5 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны 35 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “2023 онд нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо”, тус хорооноос зарласан “ТВ-Орон нутаг 2023: Орон нутагт телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалт”-ын үнэлгээний ажлын хэсгийн 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн дүгнэлтийг тус тус үндэслэн 2023 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 71 тоот тогтоолын хавсралтаар тус хорооноос 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдөр зарласан Орон нутаг телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох “ТВ орон нутаг 2023” тоот нээлттэй сонгон шалгаруулалтад Жудаг медиа пресс ХХК-ийг шалгарсанд тооцож, Өвөрхангай аймгийн нутаг дэвсгэрт (үйлчилгээ эрхлэх хүрээ) Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт заасан хугацаагаар өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгож тус тус шийдвэрлэсэн.

Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг <http://www.crc.gov.mn/main.php?cid=1&do=70&did=0> үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо
2023-06-19